

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны
...12... дугаар сарын 27...-ны өдрийн 8/НО1
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27 8/НО1

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын Мөрдөн байцаах тасаг, хэсэг

Албан тушаалын нэр:

Тасаг, хэсгийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-4

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Нутаг дэвсгэрийн цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн байцаалтын ажиллагааг удирдан зохион байгуулах, ажлын хэсэг удирдах, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, нотлох ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар болон эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, байгууллага, алба хаагч, бусад ажиллагсдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

1.Харьяалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахад зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах;
 2.Гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах;
 3.Удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлэх;
 4.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасныг хэрэгжүүлэх; 1.2.Цагдаагийн ерөнхий газар, Мөрдөн байцаах албаны даргын тушаалаар батлагдсан, дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах; 1.3.Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах.	Мөрдөн шалгах ажлын үр дүн дээшилж, шийдвэрлэлт ахисан байна.	Г, Х Г, Х Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын долоодугаар бүлгийн код 701-716 журмыг хэрэгжүүлэх; 2.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасныг хэрэгжүүлэх; 2.3.Гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох ажлыг удирдан зохион байгуулах; 2.4.Хууль сахиулах бусад байгууллагатай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах.	Гэмт хэргийн илрүүлэлт ахиж, албадын ажлын уялдаа холбоо сайжирсан байна.	Г Г, Х Г, Х Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Удирдлагаас өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлж, үр дүн биелэлтийг танилцуулах; 3.2.Цагдаагийн газар, хэлтсийн дарга болон дэд даргын эзгүйд түүнийг орлон гүйцэтгэх үед гүйцэтгэх ажил эрхлэхээс бусад эрхийг хэрэгжүүлэх.	Ажлын гүйцэтгэл сайжирна.	Г Г

Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	4.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;		Г
	4.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх;	-	Г
	4.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.		Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА


Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/		
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил, үүнээс ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах; -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай; -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх.	
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг дүгнэх.	
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх.	
	Манлайлах	-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.	
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point програмуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.	

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Батлагдсан орон тоо	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: -Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон

	<p>түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;</p> <p>Шууд бус харилцах байгууллага:</p> <p>-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.</p>
--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

<p>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</p> <p>Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА</p> <p></p> <p>Т.ГАНЗОРИГ</p> <p>2023 оны 12 дугаар сарын...-ны өдөр</p>	<p>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</p> <p>Байгууллагын нэр:</p> <p>Шийдвэрийн огноо:</p> <p>Дугаар:.....</p>
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

<p>Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</p> <p>Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр</p> <p>Дугаар: 9/401</p> <p>ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА</p> <p></p> <p>Т.СҮХБОЛД</p> <p>2023 оны 12 дугаар сарын...-ны өдөр</p>	
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------

ТАНИЛЦСАН:

<p>Албан тушаалтан:</p> <p>.....</p> <p>.....</p>

20... оны дугаар сарын-ны өдөр